

Г. Д. Санжеев. Сравнительная грамматика монгольских языков.
Т. I. – М., Изд-во АН СССР, 1953. 240 стр. (Ин-т востоковедения АН СССР.
[Оросоор) орчуулсан К.Е.Майтинская])

Лугети Л.

Энэ номыг зохиогч монгол хэлний харьцуулсан хэл зүйн бичиг туурвих гэсэн том бөгөөд хялбаргүй ажлыг хийхээр зорьжээ. Ийм зорилтыг гүйцэлдүүлэх нь хичнээн бэрхшээлтэй болохыг зохиогч өөрөө ч сайн мэдэж байна. Эл бэрхшээл нь нэгдүгээрт, түүхийн үүднээс харьцуулах арга ихээхэн учир дутагдалтай, хоёрдугаарт, монгол хэл, аялгуунууд, мөн хуучин бичгийн монгол хэлийг ч хангалттай сайн судлаагүй, зарим нэгийнх нь талаар бид бүүр юу ч мэдэхгүй байгаа хэрэг мөн гэж зохиогч үзэж байна. Үүний зэрэгцээ нэмэн дурдаж болох бусад зарим бэрхшээл нэгэнт тодорхой байсаар билээ. Гэлээ ч гэсэн зохиогч бэрхшээлээс айсангүй, бусдын эмээсэн зүйлийг зоригтой барьж авсан нь түүний гавъяа мөн. Үүнд: шинжлэх ухааны тухайн салбарт анх үүдэн оролдогчийн хялбар аятай биш боловч, онц чухал ийм ажилд алдаа мадаг байх нь аргагүй. Иймд уул номоос юуны урьд алдаа, согог эрэн өөчлөх гэх буюу эсвэл дан ганц алдаагаар нь хөөцөлдөөд, монгол хэл судлалын чухам гол бүх асуудлыг ийм өргөн хараатай авч тайлбарласан анхны зохиол болох “Монгол хэлний харьцуулсан хэл зүйн бичиг” үүний үнэ цэнийг гагцхүү алдаагийн нь үндэс болгон тодорхойлохыг оролдох гэх юм бол хэтэрхий шударга бус хэрэг болно.

Г.Д.Санжеев уг номдоо монгол хэл судлалын нэн чухал бүх ололт, зарим талаар чухамхүү зохиогчийн нэртэй холбоо бүхий ололтуудыг харгалзан авч үзсэн байна. Үүнийг харин урьд урьд үеийн судлаачдын хийснийг жирийн нэг эмхлэн дүгнэсэн хэрэг хэмээн хэлж байна гэж бодвол ташаарал болох билээ. Урьд нэгэнт тухайлан тайлбарласан зүйлсийг Г.Д.Санжеев харилцан холбоонд нь авч үзэхдээ эрс өөрөөр ухаарсан нь тус номд арвин байгааг орхин өгүүлэхэд, зохиогч энд олон асуудлыг анх удаа тодорхойгоор хөндөн тавьжээ.

Зохиогч ч уг номоо дутагдалтай гэж үзэж, зөвхөн урьдчилсан зохиол хэмээн даруухан нэрлэж байна. Эл шүүмжийг бичигч зохиогчийн нэгэн адил уг номыг урьдчилсан бүтээл гэж, тэгэхдээ огт өөр шалтгаанаар урьдчилсан гэж үзэж байгаа юм. Аливаа шинжлэх ухаан, үүнд мөн бидний судалж буй ухаанд чухамхүү жинхэнэ сайн

зохиолыг л “урьдчилсан” гэх бөгөөд тийм зохиол нь шинэ шинэ ололт, шинэ шинэ баялаг үзэл санаагаараа шинжлэх ухааны судалгааг урагш хурдавчлан ахиулж, энэ чанараараа ч эрт хуучирдаг юм. Чухам ийм утгаар л бид уг номыг урьдчилсан бүтээл гэж үзэж байна.

Бидний шүүмж бичиж буй зохиол монгол хэл судлалын нэгэн бүхэл бүтэн үе, анхны нэгтгэн дүгнэх ажилд тулж ирээд байгаа үеийн үр бүтээлийг дүгнэн гаргаж байна. Манай судалгааны ажлын орчин үеийн хэр хэмжээгээр үзэхэд зохиогчтой бидний санал бүрэн нийлж байгаа бүх асуудлыг хамгийн дэлгэрэнгүй шүүмжид ч атугай тайлбарлан гаргахын боломжгүй билээ. Гэхдээ үүнийг ярих нь бидний зорилт биш мэт санагдана. Харин бид шүүмж бичиж байгаа зохиолоосоо үндэслэн гаргаж болох монгол хэл судлалын шинэ шинэ тулгарсан асуудлыг авч үзэх ёстой гэж бодож байна.

Бидний тэмдэглэн хэлэх зүйл хоёр бүлэг болох, үүнд: нэг хэсэг нь зарчмын асуудлууд болох бөгөөд нөгөө хэсэг нь тусгайлсан асуудлыг хамарна.

Бидний хөндөн тавих гэсэн эхний асуудал бол монгол хэл судлалд түүхийн үүднээс харьцуулах аргыг бид хэрхэн зөв хэрэглэх ёстой вэ гэдэг асуудал бөгөөд энэ хэдийгээр амаргүй боловч, үүнийг тойрон гарах юм бол алдаа болно гэж бодож байна. Арвин их баримт хэрэглэгдэхүүн түшиглэн Б.А.Серебренниковын тайлбарласан түгээмэл баримтлалууд энд ч мөн ашигтай болох нь мэдээж хэрэг¹. Гэвч манай дотоодын өвөрмөц асуудлын ихэнхийг зөвхөн бид л өөрийнхөө баримт хэрэглэгдэхүүн, монгол хэлнүүдийн баримт сэлтийг түшиглэн шийдвэрлэх ёстой.

Түүхийн үүднээс харьцуулах аргыг зөв хэрэглэнэ гэхэд чухамхүү алтай хэлний судлалд л хамгийн ярвигтай юм. Түүхийн үүднээс харьцуулах арга нь энэтхэг-европын олон хэлний өөр зуурын холбоо хийгээд төрөл болохыг судлах үндсэн дээр хөгжин гарч ирсэн билээ. Судлаачдын эрхэлж ирсэн судлагдахуун нь нэн олон хэлний сүлжээ болох хийгээд тэдгээрийн ихэнх эрт балар цагаас эдүгээ үеийг хүртэлх арвин их бичиг дурсгалтай байсан нь тус аргыг хэрэглэн амжилт олсны гол баталгаа мөн болой. Үүнтэй жишиж үзэхүйеэ, алтай хэл нэн цөөн, түүнийг олон хэлний цогц сүлжээ гэж бараг боломгүй, гуравхан хэсгээс тогтоно. Эдгээр салбар тус бүрийн хэлний дурсгалын зүйл ч илүүшээх юм үгүй. Бүхэл бүтэн зүйл өгүүлсэн хамгийн эртний дурсгалууд нь бүүр манай эриний үед холбогдох, тухайлбал: түрэг хэлнийх VII-VIII зуун, монгол хэлнийх XIII зуун, манж-хамниганых XVI-XVII зууны үеийнх болно. Үүнээс арай эртний баримт гэвэл, энэхүү бүлэгт багтах зарим хэлний хэсэг бусаг үгс буй. Гэхдээ эдгээр үг цөөн бүрхэн, нөгөөтөж бүхэл бүтэн дурсгал бичгүүдтэй харьцуулахад уг хэлнийхээ төдий л их эртний байдлыг үл харуулах учир шинжлэх ухааны хувьд шийдвэрлэх ач холбогдолгүй юм.

Энэтхэг-европ хэлшинжлэлийн үүсч хөгжсөн нөхцөл харин ийм байсангүй. Хэрэв нөхцөл байдал ийнхүү аятай биш байсан аваас, түүхийн үүднээс харьцуулах арга ч үүсч хөгжөөгүй байх байсан буюу хөгжлөө ч гэсэн түүнийг хэрэглэн энэтхэг-европ

¹ Б. А. Серебренников, *К вопросу о недостатках сравнительно-исторического метода в языкознании*, ИАН ОЛЯ, 1950, вып. 3 – ыг үзмүү.

хэлний шинжлэлд олсон үр дүн нь одоогийн алтай хэлнийхээс төдийлөн дээрдэх юмгүй байх агсан болов уу. Алтайн гэж нэрлэж буй хэлнүүдийн төрөл болох нь одоо үед бид бүгдийн баримталж байгаа их л магадлалтай таамаглал мөн гэдэг ч, ийнхүү төрөл гэдгийг нь эдүгээ хүртэл шинжлэх ухааны үүднээс бас л нотолж чадаагүй байгаа, зөвхөн таамаглал төдий болно. Г.И.Рамстедтын сүүлчийн үнэт бүтээл² гарсны дараа ч гэсэн алтай хэлнүүдийн төрөл болохыг, жишээлбэл фин-угор хэлний төрөл болох буюу эдгээр хэл нохой хөлөгтний хэлтэй төрөл болохыг нотолсон лугаа адил шинжлэх ухааны үндэслэлтэй баримтаар хөдлөшгүй нотолсон гэж үзэж бас л болохгүй хэвээр байна.

Ийм ийм нөхцөл байдал байгаа гэлээ ч бид түүхийн үүднээс харьцуулах аргыг алтай хэлний шинжлэлд ч мөн хэрэглэнэ гэж үзэх ёстой. Учир нь гагцхүү энэ аргыг л хэрэглэн хэлшинжлэлийн эл салбарын зарим үндсэн асуудлыг шийдвэрлэж чадах юм. Энд дурдан буй бодит бэрхшээлүүд байлаа ч алтай хэлшинжлэлийн талаар эрт, орой хэзээ боловч байдал сайжирна гэж итгэж болно. Эдүгээгийн алтай угсааны хэлийг судлахын хувьд бас л сүрхий дутагдлууд байгаа хэдий боловч, хэдэн арван жилийн урьдахыг бодоход өнөөгийн байдал зүйрлэшгүй илүү аятай байна. Үүнд эдгээр хэлний талаар зөвлөлтийн судлаачдаас асар их баримт хэрэглэгдэхүүн хуримтлуулсныг хэлэхэд л болох байна. Эдгээр баримт нь алтай судлалын дотроос урьд огт судлагдаагүй зарим салбар, жишээлбэл, манж-хамниган хэлний тухайд үнэлж баршгүй их ач холбогдолтой юм. Эдүгээ хүртэл зохих ёсоор анхаарч үзээгүй байсан зарим бичиг дурсгалыг боловсруулах талаар ч бид мөн урагш ихээхэн ахилаа. Энэ талаар их эрчимтэй ажиллаж байгаагаас одоо онцгой баялаг үр дүн гарахуйц болоод байна. Хэрэв хэлний түүхийн талаархи зарим судалгаа амжилттай болох аваас алтайн зарим хэлний хамгийн эртний дурсгал бичгийн бичигдсэн он жилийн талаар одоо нэгэнт тогтоод байгаагаа бид удалгүй улам нарийвчлах болно гэдэгт найдаж болно. Тухайлан хэлбэл, энэ нь манж-хамниган хэлний хамгийн эртний дурсгал бичиг XVI-XVII зуунаар зогсох биш, XII зууны үеийнх болж, мөн монгол хэлний дурсгалын зүйлсийг XIII зуунаар зогсохгүй, харин X зуунаас эхлэн судлах болно гэсэн үг. Энд бид зөрчид болон хятан хэлний одоогоор тайлан уншиж, боловсруулж амжаагүй байгаа дурсгал бичгүүдийг хэлж байна. Хэлшинжлэлийн харьцуулах судалгааны үүднээс бол, он жилийн ялгаа нь гол бус, харин эдүгээ бидний мэдэж буй хамгийн эртний гэх баримт бичгийн илэрхийлж байгаа хэлний байдлаас илүү эртний байдлыг илрүүлэх нь л чухам шийдвэрлэх зүйл мөн.

Гэхдээ эдгээр судалгаа хичнээн чухал байлаа ч, бид түүнээс үндэслэн хамгийн чухал асуудал болох алтай хэлнүүдийн төрлийг батлах талаар шийдвэрлэх ахиц гаргаж чадна гэж үү дээ. Харин судалгааны аргад байгаа, урьд нь бараг огт дурдалгүй явж ирсэн нэг сүрхий алдааг бид арилгаж чадсан цагт л бид шийдвэрлэх ахиц хийж болох байна.

Түүхийн үүднээс харьцуулах аргыг хэрэглэхтэй холбогдсон нийтэд илэрхий бэрхшээлүүдээс гадна мөн өөр нэг томоохон бэрхшээл байгааг алтай хэлний судлал анхааран үзэх ёстой. Энэ нь алтай хэлнүүд эх язгуур хэлнээсээ ялгаран гарснаас хойш өөр хоорондоо төдий л саланги хөндий биш хөгжиж ирсэн явдал болно. Харин эдгээр

² G. J. Ramstedt, *Einführung in die altaische Sprachwissenschaft*, II – Formenlehre, Helsinki, 1952.

хэлээр хэлэлцэгч аймаг, ястнууд аль эрт цагаас янагш бие биен лүгээ өнө удаан хийгээд бат нягтаар хөршлөн суух нь олонтаа байсан билээ. Ийм байдал алтайн зарим хэлний үгсийн бүрэлдэхүүнд ч, хэлзүйн бүтцэд ч ул мөрөө яриангүй үлдээсэн байна. Ийнхүү нягт холбоотой байсны заримыг таамаглал гэлтгүй; бичгийн дурсгал, ихэнхдээ хятад сурвалжид энэ тухай тодорхой мэдээ их байдаг. Манай судалгааны орчин үеийн байдлаас үзэхэд, бид юуны урьд түрэг, монголын зарим аймаг, ястан хийгээд тэдний хэл, түүнчилэн монгол, манж-хамниган зарим аймаг, ястан хийгээд тэдний хэл өөр хоорондоо байн байн хөршлөн нийлж байсныг анхаарах ёстой. Энд бид уг асуудлыг нарийвчлан авч үзэж чадахгүй боловч, ойрмогхоноос анхаарал татах болсон хятан болон зөрчид хэл нь алтай угсааны ястан хийгээд алтай хэлнүүдийн сайхь холбоог тодруулахад асар их ач холбогдолтой юм гэдгийг тэмдэглэвэл зохино.

Алтай хэлшинжлэлд түүхийн үүднээс харьцуулсан судалгаа хийхдээ бид алтайн язгуур хэлийг шууд залгамжлагч мөн гэж хэл хэлнээс гарган үзэж болох хэлний баримт хэрэглэгдэхүүнийг л гагцхүү тулгуурлах ёстой гэдэг нь эргэлзээгүй.

Монгол хэлнүүдийн хувьд бол түүхийн үүднээс харьцуулах аргыг хэрэглэх нөхцөл байдлаар бусад алтай хэлийг бодвол илүү тохиромжтой юм.

Юуны урьд хэлэхэд, монгол хэлнүүдийн төрөл болохыг батлахын хэрэгцээ үгүй, эдгээр хэл үгсийн үндсэн сан хийгээд хэл зүйн бүтцээрээ нэг нэгдмэл болох нь бүүр наад захын нотолгоо ч хэрэглэлтгүй илэрхий билээ. Бидний шүүмж бичиж буй номыг зохиогч монгол хэлтэнүүд (зарим онцлог тохиол, тухайлахад монгол болон моголыг үл оролцуулбал) орос, белорусс, украинчуудын нэгэн адил өөсвөөн сайн ойлголцоно гэдгийг заан, монгол хэлнүүдийн дотор зуурын харилцааг зөв тодорхойлж байна.

Монгол хэлний цогцолбор илүү баялаг, үүнд зохиогч тэдгээрийг зургаан бүлэг болгон хувааж байгаа нь: (Афганистаны) могол, Хөх нуурын монгол (монгол, шар уйгар, шарай голынхан тэргүүтний хэл), дагуур, ойрад, буриад, төв монгол хэл - эдгээр болно. Зарим монгол хэлний талаар бас л төдийлөн тодорхойгүй байсан учир шүүмж бичигчийн бие эдүгээ хүртэл монгол хэлнүүдийг ангилах гэлгүй, гагцхүү тэдний хаана хаана суун ярьдгийг нь тоочин бичихээс хэтрээгүй билээ. Харин Г.Д.Санжеевын ангилал бол яриангүй хүлээж авмаар, санаа нь тодорхой, учирлал нь ноттой, түүгээр зогсохгүй эдүгээ төдий л сайн судлаагүй буюу бидний огт үл мэдэх хэл, аялгууг тодорхойлон гаргалаа ч, тэр нь энэ ангиллаас хэрхэвч халин гарамгүй болой.

Хэдийгээр тус тус монгол хэл хэрхэн бүрэлдэн тогтсон тухайд эдүгээ хүртэл тодорхойлж амжаагүй асуудал олон байгаа боловч, Чингис хааны удмынхны эзэнт гүрэн задран унасан цагаас хойш монгол хэлнүүд хэрхэн хөгжиж ирсэн тухай асуудал тийм ч их нарийн төвөгтэй биш юм.

Монгол хэлшинжлэлийн тулгамдсан зорилтуудын тухайд гэвэл, орчин үеийн монгол хэл, аялгууны түүхийг судлах нь нэн чухал юм гэж бид хэлэх байна. Эдгээр хэл, аялгууны талаар эмх цэгц муутай, хэсэг бусаг баримт эрхбиш бий гэлээ ч, тэдгээрийн түүхийг судлахад бэрхшээлтэй тулгарах нь яриангүй юм. Жишээлбэл: ойрад бичгийн хэлний дүрэм (тод бичиг) хос эгшгийг тэмдэглэх талаараа XVII зууны эхэн

үеийн монгол хэлэнд байсан хэлний эртний үзэгдлийг харуулж буй нь илэрхий бөгөөд зохиогч үүнийг тус номдоо маш зөв ашигласан байна. Халх аялгууны хувьд гэвэл, соёмбо үсгээр бичсэн ном зохиол үнэндээ байдаг уу гэдгийг нарийвчилан шалгаж үзвэл зохилтой; тийм ном зохиол нь тус аялгууны онцлогийг хэсэг бусаг ч болсон үзүүлэх бөгөөд энэ тухай Б.Ринчин бичиж байна³. Монгол ном бичгийн хэл буюу XVIII зууны үеийн монголын сонгодог бичгийн хэлээр бичсэн олон тооны ном зохиолд өвөрлөгч аялгуунуудын онцлог илэрдэг гэж бүүр Б.Я.Владимирцов заан тэмдэглэж байсан билээ. Нутгийн аялгууны түүхэн судлал өөр бусад олон арга, хэрэглүүр бүхий байдаг нь зүйн хэрэг. Гэтэл бид чухамхүү нэн эртний бичгийн дурсгалаас л хавьгүй их зүйлийг мэдэх болно гэдгээр гагцхан түрээ бариад, сайхь судалгааны үр дүнг бууруулан үнэлбэл алдаа болох юм.

Бид хамгийн эртний дурсгалын зүйлд боловч холбогдох нутгийн аялгууны асуудлыг анхааран үзэх ёстой, тэгэх тусмаа уг асуудал монголын хуучин бичгийг хэрхэн авч хэрэглэсэнтэй холбогдон басхүү нэн чухал болж байгаа юм.

Монголын хуучин бичгийг авч хэрэглэсэн тухай асуудлыг шинжлэх талаар ч, монголын хуучин бичгийн хэлнүүдийг судлах талаар ч эдүгээ бид монгол хэлшинжлэлийн эл салбарыг үүдэн гаргагч Б.Я.Владимирцовын хийснээс цааш ахиагүй байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд, монголчууд бэлхэн бичгээр зогсохгүй, басхүү бэлхнээ боловсорсон бичгийн хэлийг ч авч хэрэглэсэн байна гэдэг дүгнэлт хийж болно хэмээн зохиогч дурдаад, харин энэ бичгийн хэлний тулгуур үндэс нь чухам юу болохыг бид мэдэхгүй байна гэжээ. Үүнд хуучин бичгийн хэл нь одоогийн монгол хэл, аялгуунуудыг судлаад тайлбарлачихаж боломгүй хэлний, тодорхой хэлбэл, аялгууны тийм онцлогтой байгаа нь гол бэрхшээл болно. (Нутгийн аялгууны түүхэн судлалыг явуулахад гарч байгаа гол дутагдал чухам энд л онц мэдэгдэм байна.) Тухайлахад, **kūmūn**, **keme** гэх мэтийн жишээгээр илрэх нутгийн аялгууны нэгэн хэсэг онцлогтой гол төлөв уялдсан шийдвэрлэгдэмгүй зорилт бидний өмнө гарч ирж байна.

Ийм ийм үндсэн бэрхшээлээс болоод хуучин бичгийн монгол хэлийг гаднаас сурвалжтай хэмээн хайх болж, эдүгээ хүртэл судлагчид юуны урьд найман, хэрэйдийг зааж байна. Найман, хэрэйдийн хэл буюу аялгуунаас ямар ч бичгийн дурсгал үлдэж ирээгүйн учир энэ бол зөвхөн хирцүүлэл юм гэдгийг зохиогч сайн мэдэж буй аж. Найман хэл буюу аялгуунаас эх авсан байж болохын тухайд гэвэл, Чингис хаан Тататунга нэрт найман “бичээчээс” нэгэн бичигтэй тамга олж, түүнийг шадар албандаа авсан гэдэг мэдээ байдгийг дурдаж болох билээ. Гэтэл уг хэрэг тийм ч хялбар тайлагдамгүй байна. Учир нь Чингис хааны үед найманчууд урьдын түрэг хэлээрээ л ярьж байсан гэдгийг бид сайн мэднэ шүү дээ. Мөн “Монголын нууц товчоонд” гардаг найманы газар ус хийгээд хүний нэр ихэнхдээ түрэг гаралтай үг байдгийг үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд онц сонирхолтой юм. Тататунга хуучин бичгийн хэлийг найманаас Монголд дамжуулсан гэж үзлээ ч гэсэн уг хэл найманд хаанаас, хэрхэн хүрч ирсэн юм бэ гэсэн асуулт даруй гарч ирэх билээ. Хэрэйд хэл буюу аялгуунаас сурвалжтай гэдэг таамаглалын хувьд бол, энэ нь бас л үндэстэй, тэгэхдээ бүүр

³ Rintschen, *Zwei unbekannte mongolische Alphabete aus dem XVII. Jahrhundert*. “Acta Orientalia”, t. II. fasc. 1, Budapest, 1952.

найманыхаас ч арай илүү үндэстэй юм. Эл таамаглал найманаас баригдсан “бичээч” шиг “биет” баримтгүй нь мэдээж хэрэг. Гэхдээ Чингис хаан өөрийн эзэнт улсыг байгуулах, дотоодыг тохинуулахдаа хэрийдээс олонтаа үлгэр авч байсан нь баримттай бөгөөд энэ тухай “Нууц товчооны” хэд хэдэн газар өгүүлнэ. Сүүлийн үеийн судалгааг үндэслэн хуучин бичгийн монгол хэлийг хятан хэлнээс гаралтай гэж үзэж болохгүй юу гэсэн бас нэг таамаглалыг хэлж болох байна. Ийм таамаглал байж болох тухай бид дараа ярих болно. Харин энэ асуудлыг эерэг буюу сөрөг аль нэгнээр шийдвэрлэх нь бидний боломжийн хэрээс шалтгаалах хэрэг гэдэг нь илэрхий юм.

Монгол хэлийг түүхийн үүднээс харьцуулан судлах аргазүйн бас нэг асуудлыг авч үзэлтэй байна. Уг асуудал анхлан харахад нэн хялбар санагдаж болох боловч, үнэндээ тун ч амаргүй бөгөөд түүнийг нарийвчлан тодруулбал зохино гэдгийг монгол хэл судлалын урьд урьдын туршлага харуулж байгаа юм.

Орчин үеийн монгол хэл, аялгуунууд түүхийн урт удаан хөгжлийн үр бүтээл болох бөгөөд эдгээр хэл, аялгууны хөгжин гарч ирсэн угийн түүхт байдлыг авч үзэх л юм бол, тэдгээрийн өөр хоорондын уялдааг бид ойлгож сая чадна. Тэр анхны нэгдмэл байдал юугаар илэрч байна вэ? “Хуучны” монгол хэл үүнийг харуулж байна уу? Монгол хэл, аялгууны түүхийн үндсэн асуудал чухам энэ юм аа. Монгол хэлийг бусад алтай хэлтэй харьцуулан үзэхэд, төрөл гэж буй эдгээр хэлнээсээ үгсийн үндсэн сангийн хувьд ч, хэл зүйн байгууллын хувьд ч эрс ялгаатай юм. Хэрэв бид бүх алтай хэл судлаачдын үзэж байгаачлан, эдгээр төрөл хэл урьд нэгэн цагт нэг нийтлэг байсан гэх аваас, тэр цагт үгсийн сан болон хэл зүйн эдгээр ялгаа нэгэнт байгаагүй, өөрөөр хэлбэл эдгээр ялгаа нь алтай хэлний нийтлэг задрахаас өмнө гагцхүү нутгийн аялгууны ялгавар төдий л байсан байж таарна. Түрэг хийгээд монгол хэлний хоорондын одоогийн эрс ялгаа зөвхөн түрэг хэлнүүд түүхэн хөгжлийн үлэмж их өөрчлөлт үзсэнээр л бий болоогүй нь мэдээж хэрэг. Энэ нь алтайн язгуур хэлнээс салбарлан гарсан эртний монгол хэл ч мөн асар их өөрчлөлт үзсэн гэсэн хэрэг болно. Эл бүхий өөрчлөлт болсноор уг хэл бидний хамгийн эртний бичиг дурсгалаар нь мэдэж байгаа XIII зууны үеийн монгол хэлний байдлаас ялгарна. Эдгээр асар их өөрчлөлт шууд, тэсрэлтээр гараад ирчихээгүй, асар удаан хугацааны аажим хөгжлөөр буй болсон ажгуу.

XIII зууныг хүрч иртэл монгол хэл хөгжлийн хэр урт замыг туулсан байх нь вэ? Бид үүнийг ойролцоогоор ч гэсэн тогтоож чадахгүй нь мэдээж билээ. Гэхдээ хэрэв бид VII-VIII зууны үеийн түрэг хэл орчин үеийн түрэг хэлнүүдтэй харьцангуй ойролцоо байгаа атал, XIII зууны үеийн монгол хэлнээс огт өөр байгааг бодож үзвэл, манай эрний өмнөх нэг, хоёрхон зууны үе гэхэд түрэг, монгол хэлний аль аль нь алтай язгуур хэлнээсээ хараахан салбарлан гараагүй байсан гэж зарим түрэгч хийгээд монголч эрдэмтдийн таамнан үздэгийг бид эрс няцаах ёстой болно.

Чингэхлээр, монгол хэл бусад төрөл хэлнээсээ салсан цагаас эхлээд XIII зууны угтал зуунуудыг хүрч иртэл асар удаан хугацаанаа тогтон хөгжсөн гэдэг нь эргэлзээгүй юм. Энэ завсар монгол хэл хэрхэн хөгжиж агсан бэ гэвэл, бид одоогоор үүнийг тун бага мэднэ. Гэлээ ч чухамхүү түүхийн үүднээс харьцуулах аргыг хэрэглээд, судалж буй хэлнийхээ энэ үеийн хөгжил хоёр шатыг туулсан тухай зарим дүгнэлт хийж болох байна.

Эхний шат нь монгол хэлний тогтож ирсэн хамгийн эртний үе болно. Монгол хэлний түүхийн урьдчилан таамаглаж буй эл эртний үеийг өвөг монгол хэлний үе хэмээн нэрлэж болох бөгөөд энэ нэр зөвхөн тоймлосон харьцангуй утгатай, үүний оронд илүү зохимжтой өөр нэр томъёо хэрэглэсэн ч болох тул энэ нэрийн тухайд маргах нь утгагүй хэрэг. Монгол хэлний хөгжлийн нөгөө хоёрдугаар үе нь бидний мэдэж буй хамгийн эртний бичгийн баримт болох XIII зууны үеийн дурсгалын зүйлд илэрч байгаа үед тулж ирсэн угтал үе нь юм. Энэ үеийг бид эртний монгол хэлний үе гэж нэрлэж байгаа болохоор хуучин бичгийн хэл бол дундад үеийн монгол хэлд орох нь мэдээж хэрэг.

Өвөг монгол хэлний тухайд бол, бид гагцхүү монгол хэлтэй төрөл түрэг, манж-хамниган хэлнүүдийн баримт хэрэглэгдэхүүнийг ашиглаж, мөн түүнчилэн эртний монгол хэлний баримтыг үндэс болгон хийсэн дүгнэлтүүдийг тулгуурлан ямар нэг хэмжээгээр түүнд ойртож очиж болох юм. Харин алтай хэлийг түүхийн үүднээс харьцуулсан шинжлэлийн одоогийн байдлыг анхаарч үзээд, мөн эртний монгол хэлийг эрэмбэ цэгцтэй судлах талаар бид байваас зохих үр дүнд хүрэхэд бас л хол байгаагаа бодоход өвөг монгол хэлний хувьд одоогоор зөвхөн бүдэг бадагхан таавар төдийтэй байгаа нь гайхах хэрэг биш ээ. Чингэхлээр, энэ хэлний тухай ямар нэг тодорхойхон төсөөлөлтэй байна ч гэж хэлэхийн аргагүй байгаа юм.

Эртний монгол хэлний талаар зарим бэрхшээлтэй зүйл мөн байгаа хэдий боловч, наад зах нь гэхэд зарчмын хувьд үлэмж дээр байна.

Онолын үүднээс нэхэн гаргаж, од тавин тэмдэглэдэг бөгөөд бодит байдалд гагцхүү бүдүүн тоймоор ойртох хэлбэрүүд нь хэлний хөгжлийн жинхэнэ явцыг тусгаж тэр бүхий чаддаггүйг юуны урьд тэмдэглэвэл зохино. Гэхдээ бид ямагт үүнийг бодоод, од тавин тэмдэглэсэн хэлбэрийг догма болгон үзэхгүй байх аваас, ялангуяа хэлийг орон, цаг хийгээд уг хэлэлцэгч ард түмний түүхээс салган үзэж хэзээ ч болохгүй, хэлийг эгнэгт тогтсон зүйл мэт метафизикээр үзэж болохгүй гэдгийг үл умартах аваас бид судалгаандаа зөв замаас гажна гэж үү.

Бидний мэдэж байгаа, монгол хэлний хамгийн эртний дурсгал нь XIII зууных билээ. Гэхдээ энэ хугацааг бид ягштал баримтлах ёсгүй. Эдгээр дурсгал бичигт туссан монгол хэлний байдал зөвхөн XIII зууны үеийнх биш гэдэг нь маргаангүй. Учир юун хэмээвээс, монгол хэлний, нарийвчилан хэлбэл уг дурсгалыг бичсэн нутгийн аялгууны байдал нь XIII зуунаас 100-200 жилийн урьдных байж болох юм.

Монгол хэлийг түүхийн үүднээс харьцуулан судлах шинжлэлд онцгойлон анхаарах ёстой бас нэг нэн чухал асуудал байна. Үүнд судалгааг хоёр талаас явуулж болно. Нэг бол бид орчин үеийн хэлний буюу бидний мэдэж буй эртний нэгэн хэлний баримт хэрэглэгдэхүүнийг тулгуурлан, уг хэлний одоогийн байдлын эх үндэс болсон урьдны байдлыг нь сэргээн гаргахыг оролдож (асцендент буюу өгсөн босгох арга хэрэглэж), эсвэл бид тухайн хэлнийхээ өөрийн төсөөлж байгаа буюу биечлэн мэдэж байгаа нэн эртнийх нь байдлаас уг хэлний орчин үеийн байдлыг ургуулан тайлбарлахыг оролдож (десцендент буюу уруудан гүйцэх арга хэрэглэж) байна. Энэ эцсийн аргыг онц их төвөггүйгээр хааяа нэг хэрэглэж болох нь нийтэд илэрхий билээ. Түүнийг роман

хэлшинжлэлд хэрэглэж байсан бөгөөд сонгодог латин хийгээд дундад эртний үеийн хар ярианы латин хэлийг мэдэж байсан нь хэл шинжлэлтэн нарт ингэж судлах боломж бий болгоод зогсохгүй, ингэхийг бүүр зайлшгүй болгосон юм. Харин энэ хоёр аргыг бие биед нь эрс сөргүүлэн тавьж болно гэж үү. Ямар ч атугай, энэ хоёр аргад шүүмжлэлтэй хандаж, диалектик ёсоор нэгтгэн үзэх хэрэгтэй. Бидний шүүмж бичиж буй номын зохиогч ч чухам ингэж зөв хандсан байна.

Энэ номын зохиомж, бүтэц нь тодорхой юм. Бичлэгийн найруулга хялбар (үүнийг харь хэлний хүн хэр зэрэг шүүн тодорхойлж болох билээ); ямар ч байлаа гэсэн энэ ном эхнээсээ дуусан дуустлаа уншихад их л сонирхолтой; эргэлзээ төрмөөр газар нь хүртэл амтархмаар бичигджээ. Тус номд ололттой сайн зүйл арвин буйн тул бид түүнийг их сургуулийн оюутнуудын суралцах бичигт тооцож байна.

Биднийг бодоход, Б.Я.Владимирцовын сонгодог зохиол⁴ лугаа нэгэн адилаар энэ номд монгол хэлтэй төрөл гэж үзэж байгаа хэлнүүд болон алтай хэл судлалын одоогийн байдалтай уншигчдыг товч танилцуулах бүлэг буюу хэсэг оруулсан бол сайн байх агсан. Зохиогч нэлээд олон асуудлаар алтайн бусад хэлнээс эш татан зааж байгаа, заримдаа алтай судлалын асуудалд бэсрэгхэн бүлэг тусгайлан зориулсан ч байгаа тул ингэх нь бүүр чухал юм. Нөгөө талаар зохиогч алтай хэлнүүдийг нэн тодорхой авч үзээгүйг бид зөв гэж бодож байгаа бөгөөд алтай судлалын одоогийн байдалд ингэж үзэх боломж ч байна гэж үү. Алтай хэлний илүү тодорхой ийм судалгаа хэрэгтэй боловч, энэ нь бидний шүүмж бичиж байгаа номын хэмжээнээс хальсан асуудал болно.

Мөн монгол хэлнүүдийн урьдны байдлын тухай арай илүү тодорхой бүлэг байвал нь (дараагийн хэвлэлд) бид дуртайяа унших агсан билээ.

Монгол хэл үүсэн тогтсоныг Чингис хаан түүхийн тавцанаа гарч ирсэнтэй холбон үзэж болохгүй нь илэрхий. Зохиогч ч мөн ингэж үзэж, зарим үзэгдлийг манай эриний VII зууны үеийнх гэж таамаглаж байна (жишээ болгож, номын 94 болон 100 дахь талд буй хүснэгтийг үзмүү). Гэхдээ эл асуудал зөвхөн онолын үндэслэлтэй биш ээ.

Зарим судлагчийн үзэж байгаагаар бол, жуань-жуаньчууд, панноны (одоогийн баруун Унгарын нутаг дээр агсан) аварын зарим нь, мөн эфталичууд монгол хэлээр ярьдаг байсан бололтойг ямар ч гэсэн дурдалтай байна. Нэлээд тодорхойхон дүгнэлт хийхэд хэлний баримт хэрэглэгдэхүүн асар хомс байгаа учир энэ нь хараахан хирцүүлэх төдий болно. Гэвч эл хирцүүлэл хоёр зүйлийн шалтгаанаар анхаарал татаж байна. Эдгээр нэгэнт мөхсөн эртний аймаг, ястны хэлний хамаарлын тухай асуудлыг шийдвэрлэнэ гэвэл, зөвхөн хэл шинжлэлтэн нар л шийдвэрлэж чадна. Нөгөө талаар Чингис хааны үеэс аль өмнө монгол гэж үл нэрлэгдэх аймгууд ч монгол хэлээр ярьж явсан нь онолын хувьд тодорхой болно.

Практик талаасаа бол, Байгал нуураас урагш, Хянганаас баруунш, зүүн тийшээ Ляодун хүртэлх нутагт манай эриний эхний зуунуудад монгол хэлээр хэлэлцэгч олон

⁴ Б. Я. Владимирцов, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*. Л., 1929, 44 дэх болон дараагийн талуудыг үзмүү.

аймаг нутаглаж байсныг үсэг бичгийн дурсгалаас үндэслэн баталж болно гэдэг нь чухал юм. Үүнд урьд хамнигануудтай адилтган эндүүрч байсан дүн-хү нар шүннүтэй байлдаж ялагдсаныхаа дараа у-хуань, сянь-би гэж хоёр хэсэг болон задарсан нь илэрхий билээ. Энэхүү сянь-би нарын тухайд хятадын тулгар бичгүүд манай эриний 45 оноос эхлэн нэлээд тодорхой мэдээ дурдан гаргасан байдаг. Тэднээс нэг талаар си⁵ болон хятан аймаг, нөгөө талаар нэлээд хожим а-жа нарын бүлэг салбарлан гарчээ. А-жаг хятадаар ту-юй-хунь, төвдөөр *ha-ja* гэж нэрлэнэ.

Эдгээр а-жа нар барагцаалбал манай эриний 250 оны орчим Ляо голын сав хавиас Ганьсугийн хойд хэсэгт нүүдэллэн очиж, хожим нь IV зууны үед Хөх нуураар нутаглах болжээ. Тэд энд суурьшин тусгаар улс байгуулсаныг 663 онд төвдүүд цохиж устгасан байна. Хятанчуудын тухай хятадын түүхчид 406 оноос эхлэн дурдах бөгөөд цаашдаа тэдний талаар улам бүр дэлгэрэнгүй баримт сэлт заан гаргадаг. Хятанчууд X зууны үед Умард Хятадыг түрэн эзлээд, 907 оноос 1125 он хүртэл Ляо хэмээх хятаны эзэнт улсыг тогтоон авай. Түүнчилэн сянь-би аймгийнхны нэгэн бүлэг нь умардаар нутаглан Байгал нуураас урагш, одоогийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зүүн хойт нутаг, мөн түүн лүгээ зэргэлдээ Зүүн хойт Хятадын хязгаар нутгийг эзлэн сууж байв. Эдгээр аймгийн холбоог хятад сурвалжид Тан улсын үеэс (VII-X зуун) эхлэн ши-вэй гэдэг нэрээр өгүүлнэ.

Хэлшинжлэлийн талаар гэвэл, хамгийн илт мэдэгдэх сянь-би үгсийг саяхан хятадын эрдэмтэд эмхлэн гаргалаа⁶. Эдгээр үг монгол судлалд ач холбогдолтой нь огт эргэлзээгүй боловч, түүнийг эдүгээ хүртэл хэлшинжлэлийн хувьд боловсруулж чадаагүй нь харамсалтай байна. Мөн нэгэнт уламжилж ирсэн хятан хэлний бичгийн дурсгалыг боловсруулахын хувьд ч үүнээс дээрдэх юм алга. Хятад сурвалжаас түүн олж болох хятан үгс лавтай зуу гаруй байгаа юм. Түүний ихэнхийг онцын бэрхшээлгүй тайлан уншиж болох бөгөөд хятан хэл монгол хэлэнд хамаарагдах нь маргаангүйг эдгээр үг гэрчилж байна. Уг хэл XIII-XIV зууны үеийн монгол хэлийг бодвол нэлээд эртний шинжтэйг (үгийн эхний **h** –гийн оронд басхүү **p** байсаар байдаг) тогтоож болно. Үүнээс гадна энэ хэл зарим нэгэн ноцтой онцлог бүхий бөгөөд нэлээд их тагнайшсан аялгуу болох юм. Үүнд: **jau, taw, towus, nair, sair** (монгол бичгийн хэлний: *jaγun, tabun, toγusun, naran, saran* гэдэгтэй тохирох) гэх мэт хэдэн хятан үгийг дурдъя. Хятанчууд бичиг үсэгтэй, тэгэхдээ бүүр хоёр зүйлийн бичигтэй байжээ. Түүний нэгийг хятадууд “бага үсэг” хэмээн нэрлэж байв. Энэхүү “бага үсэг нь” тоогоор цөөн, холбон бичдэг байжээ. Энэ нь уйгар бичиг байсан байж болох юм; гэвч түүгээр бичсэн дурсгалын зүйл хадгалагдаж ирсэнгүй. Хятаны нөгөө нэг бичиг нь хятадаас гаралтай, “их бичиг”

⁵ Хятад сурвалжид гардаг *си* нарыг В. Томсен **t(a)t(a)bī** –тай холбоотой хэмээн таамаглаж байсан билээ (V. Thomsen, *Inscriptions de L'Orkhon*, Helsingfors, 1896, 141 дэх талаас үзмүү). Энэ таамаглалыг одоо хараахан нийлэгдээгүй байгаа. X зууны үеийн нэгэн төвд гар бичмэл бүрэн баталж байна. Уг гар бичмэлд дурдахдаа: төвдүүд **he** гэж нэрлэдэг аймгийг хятадууд **he-ce** гэдэг, харин дргү-гү нар (түрэгүүд) **dad-pji** гэдэг хэмээжээ. Эл сүүлчийн нэрийг **tatbī** гэж уншиж болох бөгөөд харин төвд бичгийн дурсгалд, ялангуяа харь хэлний үгийг тэмдэглэхэд үсэг зүүсэн буюу үгүй нь нэлээд учир холбогдолтой байдаг нь харамсалтай. Энэ нь тус нэрийг **tatbī** хэмээн хирцүүлэн уншсан нь зөв болох аваас **tatabī** хэмээн уншиж болохыг мөн үгүйсгэлтгүй гэсэн хэрэг ээ.

⁶ Фан Чжун – ю. *Сянь-би юй-янь као*, “Yenching Journal of Chinese Studies”. 1930, 1429 дэх талаас үзмүү.

хэмээгч бөгөөд барагцаалбал 3000 орчим тэмдэгтэй байв. Саяхан болтол тус бичгээр бичсэн томоохон дурсгалын зүйл олдоогүй байлаа. Гэтэл 1922 онд Хятан улсын хааны эртний нэгэн булшнаас хятад орчуулга хавсаргасан хоёр дэлгэрэнгүй бичээс олдсон билээ. Түүнээс хойш өөр өөр дурсгалууд олдсоор одоо бид нэгэнт дөрвөн том, мөн хэд хэдэн жижиг бичээстэй болоод байна⁷. Харамсалтай нь, тэр бүхнийг эдүгээ хүртэл хараахан уншиж чадаагүй учир уг бичээсүүд дуугарч чадахгүй байсаар байна. Хэрэв хэн нэгэн хүн түүнийг тайлан уншваас монгол судлалд онцгой том үйл явдал болох билээ.

Хятан улсын үед жинхэнэ монголчууд хаагуур нутаглаж байв аа? Тэр цагт жинхэнэ монголчууд ши-вэй нарын дотор багтаж явсан хэмээн бид энэ асуудлыг эдүгээ төвөггүй хариулж чадна. Тан улсын үеийн хятад сурвалжид ши-вэй аймгуудыг дурдан тоочсоны нэг нь мэн-ү буюу мэн-ва⁸ гэсэн нэртэй байдаг. Энэ нь яриангүй, “монгол” гэдэг нэр мөн хэмээн заан тэмдэглэцгээсээр ирэв. Хэрэв жишээ нь: “Нууц товчоонд” гардаг хамгийн эртний үйл явдлуудын болсон газар усны нэр буюу ирээдүйн Чингис хаан болох Тэмүүжин бага залуудаа хаагуур нутаглаж байсан хийгээд түүнчлэн Тэмүүжингийн үеийн монгол аймгуудын аж байдлыг анхааран үзвээс, эд бүгд үндсэндээ эртний ши-вэй нарын сууж агсан тэр л нутагт болж байсан нь илт харагдана.

Ийм ийм нөхцлийг аваад үзэхлээр, XII-XIV зууны үед монгол хэл нэгдмэл байсан гэж зохиогчийн баталж буйг шүүмж бичигч яагаад зөвшөөрөхгүй байгаа нь ойлгомжтой болох буй за. Тэр үед монгол хэл нэгдмэл байсан мэтээр үздэг, ерөөс тийм ч хялбар тайлбарлагдамгүй үзэл нь чухам юунд тулгуурласан юм бэ гэдэг бол сайхь баталгаанаас гарцаагүй гарах үндсэн асуудал мөн бөгөөд үүнийг хариулж чадахгүйдээ би ингэж ярьж байгаа юм биш ээ. Энэ асуудлыг: нэг бол монгол хэл XII зуунаас ч өмнө нэгдмэл байсан, эсвэл урьд нь нэгдмэл байгаагүй ч гэхнээ уг хэл Чингис хааны үед нэгдмэл болсон гэдэг хоёрхон зүйлээр л хариулчихаж болно.

Өвөг монгол хэлнээс дундад үеийн монгол хэл хүртэлх хөгжлийн явцад гарсан асар их өөрчлөлтүүдийг бүх монгол аймаг, ястнууд хөгжлийн хэр хэмжээний ямар ч ялгаваргүйгээр бүгд нэгэн адил үзэж өнгөрүүлсэн гэвэл зарчмын хувьд ч төсөөлөхүйеэ бэрх юм. Энэ тухайд бол хөгжлийн эхний үе шат төдийлөн үүрэг холбогдолгүй болно. XII зууны угтал үед нэгдмэл байсан гэж таамаглаж болох уу гэдэг асуудал л чухам гол юм. Онолын үүднээс бол энэ тухайд ч гэсэн, тэр үед монгол хэл нэгдмэл байсан гэдгийг төсөөлөхүйеэ бэрх юм. Наанадаж ши-вэй, хятан хийгээд ту-юй-хунь буюу а-жа гэсэн монголоор ярьдаг гурван төв байсныг бид харгалзан үзэх ёстой гэдэг нь сурвалж бичгүүдээс үзэхэд илэрхий шүү дээ. Гэтэл эл гурван төв тус бүр ч атугай дотроо хэлний хувьд нэгдмэл байсан хэмээн хэлж болно гэж үү гэдгийг баримт гэрчилж байна. Тийнхүү бидний мэдэж буй хятан үгсээс авч үзэхэд, хятан хэл дотроо нутгийн аялгуунуудтай байсан болохыг харгалзан үзэх хэрэгтэй бөгөөд тэдгээрийн өөр хоорондын ялгаврыг тийм ч бага гэж үзэж болохгүй гэсэн дүгнэлт хийх ёстой болж байна.

⁷ “Ляо-пин ши-кэ цзи-пү”. Фэн-тянь, 1932-ыг үзмүү.

⁸ “Цзю Тан-шү” 199в, 10а; “Синь Тан-шү” 219, 7а –гаас үзмүү. Сүүлийн хуудсанд “ва” гэж дуудагдах дүрс үсэг бий. Гэтэл бидний энд хуудас зааж буй Бэ-на-гийн хэвлэлээс үзэхэд энэ нь зөвхөн бичгийн мадаг болох бөгөөд яв явсаар хоёр сурвалжид хоёуланд нь “мэн-ү” гэж уншигдах нэр байгаа нь илэрхий болно.

Гэхдээ Чингис хаан байлдан дагуулж, гүрэн улс байгуулсан нь хэлний хувьд тодорхой хэмжээний цомхотгол болсныг эргэлзэх зүйлгүй. Гэвч энэхүү цомхотгол нь төв нутгийн аялгуудыг илүүтэй хамарч, харин зах хязгаарын аялгуунууд түүнд багаахан өртжээ. Персийн түүхч Рашид-ад-дин ойрдуудын хэл яриа бусад монголчуудынхаас хэр зэрэг ялгаатай байсныг харуулах олон жишээ гаргасан байдаг нь санамсаргүй хэрэг биш ээ. Үүн лүгээ нэгэн адилаар Монголын эзэнт гүрний зах хязгаар нутагт хэлэлцэж агсан буриад хэл зөвхөн XV зуунаас хойш өөрийн өвөрмөц онцлогтой болсон гэж үзэхэд басхүү бэрх юм. XII-XIV зууны үед монгол хэл нэгдмэл байсан гэдэг үндэслэлийг сөрөн сааруулах иймэрхүү нөхцөл байдал олон байгааг тоочиж болох гэлээ ч, үүнийг тодорхой авч үзвэл уг шүүмж хэт сунжрах билээ.

Харин зохиогч өөрийн үзлийг цаашид баримтлахыг (хэрэв энд дурдан буй учирлалууд түүнийг үл итгүүлэх аваас, тэгэж баримтлах нь зохиогчийн эрхийн хэрэг) үгүйсгэж болохгүй, гэхдээ энэ үзэл гагцхүү таамаглал л байх болно. Хожмын судалгаа энэ асуудлыг яриангүй төгс шийдвэрлэх хэрэг. Гагцхүү шүүмж бичиж байгаа зохиолд тайлбарласан үзлийг цорын ганц зөв үзэл гэх буюу ямар ч маргаангүй гэх нь зохимжгүй, учир юун хэмээвээс, ингэж үзээд ирэхлээр тэр нь цаашдын судалгааг урагш хөдөлгөх байтугай, харин даруй боон саатуулах болох билээ.

Монгол хэл судлалын өнөөгийн бидний үе нь XIX, XX зууны зааг дээрх түрэг судлалын үе, тухайлбал Орхон, Енисейн бичээсийг тайлан уншиж, уйгарын болон бусад их бага дурсгалууд, заримдаа бүүр гайхамшигтай сонин баримтыг өгүүлсэн үлэмж том хэмжээний бичиг дурсгалыг олж байсан үеийг их л санагдуулж байна. Сүүлийн хэдэн арван жилээс эхлээд өнөөдрийг хүрч иртэл нэлээд том хэмжээний шинэ шинэ бичиг дурсгалыг их хэмжээгээр судалж байгаагаараа бид XIII-XIV зууны үеийн монгол хэлийг урьдынхаас эр өөрөөр үзэх болов. XII зуунаас өмнөх үеийн монгол хэлийг илрүүлэн гаргахад чиглэсэн асар их бэрхшээл бүхий судалгаа одоо үлэмж далайцтай болж байна. Манай шинжлэх ухааны хөгжлийн орчин үеийн шатанд бид нэгтгэн дүгнэсэн бодомжийг томъёолоход нэн болгоомжтой байх ёстой мэт санагдана. Тэглээ ч гэсэн эцэст нь монгол хэлний харьцуулсан судлалын салбар дахь одоогийн шинжилгээний үр дүн гэж болмоор дүгнэлтүүдийг хэдэн жишээ татан харуулъя гэж бодож байна.

Монгол хэлний **či, ji** -гийн гарал ***ti, *di** болох нь аль хэдийнээ илэрхий билээ. Тус номыг зохиогчийн үзэж байгаагаар бол, эл угийн байдал нь VII-X зууны үед байсан гэнэ (94,100 дахь талд). Үүнтэй холбогдуулан жишээ авч үзье. 813-814 онд бичиж дуусгасан хятадын нэг сурвалжид нэгэн уулын нэр гарах бөгөөд хятад зохиогчийн бодож байгаагаар бол ту-юй-хунь нарын хэлээр⁹ түүнийг хо-чжень “гуч” гэнэ. Энэ үг тэр цагийн хятад хэлний дуудлагаар бол авиазүйн хувьд харь хэлний **yuč'in** буюу **yurč'in** гэсэн үгтэй тохирох юм. Энэ нь монгол үг мөн бөгөөд харин түүнд **r** авиа байсан эсэхийг хэлэхэд бэрх юм. Гагцхүү хамгийн наад зах нь гэхэд VIII зууны эцсийн үеийн энэ үгэнд ***ti** – гийн оронд **či** байгаа нь ямар ч эргэлзээгүй. Үүнээс үзэхэд **ti > či** -гийн он цагийг зохиогчоос тогтоосон нь ташаа биш үү гэвэл, огт нь тийм биш. Үүнээс юу

⁹ Хятан хэл, ту-юй-хунь хэл хоёр холбоотой болохыг L. Hambis, *Note sur Les *Tuyurün*, "Journal Asiatique", t. CCXXXVI, fasc. 2, 1948 –аас үзмүү. Ту-юй-хунь хэлний үгсийн тухайд P. Pelliot, *Neuf notes sur des questions d'Asie Centrale*, "T'oung Pao", vol. XXVI, No 4-5, 1929, 250-252 дахь талаас (VIII – Un mot mongol sous les T'ang) үзмүү.

харагдах вэ гэвэл, гагцхүү VIII зууны үед сайхь шилжилт нэгэнт гүйцэж төгссөн монгол хэл (буюу аялгуу) байжээ гэдэг л харагдана.

Цааш нь. Үгийн эхний **si-** хоёр асуудалтай холбогдох юм. Үүнд: 1) Хэдий үеэс эхлэн **i** –гийн өмнө болохоор **s** гэхгүй, **š** гэж дуудах болсон бэ? 2) Үгийн эхний үеийн **i** эгшиг хэдийд нугарах болж эхлэсэн бэ? Үүнтэй холбогдуулан бид л бол хятан хэлнээс хоёр жишээ авах байна. Хятад толь бичгээр бол хятан хэлэнд **šawa** буюу **šawā** “бүргэд” (монгол бичгийн хэлний **sibayun**) гэдэг үг, мөн **šawaji** буюу **šawāji** (монгол бичгийн хэлний **sibayuči**) гэдэг үг байсан байна. Чингэхлээр энэ жишээ нь **i** эгшиг хятан хэлнээ нугарсан байсныг гэрчилж байна. Гэтэл мөн хятад бичгээс олсон өөр нэг жишээ нь **sibaq** “шаваг” (монгол бичгийн хэлний **sibay**) гэж, харин ч ийм нугарал гараагүй байсныг гэрчилж байна. Ийнхүү тус хоёр сурвалжид нутгийн аялгууны зөрөө байгаа нь харагдаж байна.

Нэлээд хожим нээн олсон XIII-XIV зууны үеийн монгол хэлний баримт хэрэглэгдэхүүн нь улам ч их зүйлийг илрүүлэх дүгнэлт хийхүйц болгож байна. Эдгээрийг хэлшинжлэлийн үүднээс ашиглахын тулд урьдчилан дуун ухааны үүднээс боловсруулваас зохих бөгөөд эл баримт сэлтийн ихээхэн хэсгийг ингэж боловсруулаагүй байгаа тул хэрэглэхэд багагүй бэрхшээл байсан авч, зохиогч түүнээс нэлээд олон зүйл нэгэнтээ ашигласан байна.

Гуравдугаар биеийн төлөөний үгийн тийн ялгалын хэлбэрээс зохиогчийн авч үзсэн нь (152 дахь талд): ганц тоот харъяалахын тийн ялгалын **inu**, өгөх оршихын тийн ялгалын **imadur**, заахын тийн ялгалын **imayi**, олон тоот харъяалахын тийн ялгалын **anu**, заахын тийн ялгалын **ani** эдгээр болно. Шинээр нээсэн баримтыг ашиглан бид цааш нь ганц тоот өгөх оршихын тийн ялгалын хэлбэр **imada** (“Нууц товчоо”), үйлдэхийн тийн ялгалын **ima'ari** (“Нууц товчоо”), гарахын тийн ялгалын **imadača** (1338 оны хятад-монгол бичээс), хамтрахын тийн ялгалын **imaluy-a** (1335 оны хятад-монгол бичээс), олон тоот өгөх оршихын тийн ялгалын **andur** (“Нууц товчоо”) хийгээд **ana** (1291 оны бичиг) - эдгээрийг нэмэж болох байна.

Олон тоотыг илэрхийлдэг **-n** лугаа холбогдуулан тус дагавар буриад хэлэнд байдаг тухай зохиогч маш сонин зүйлийг тэмдэглэж байна (133 дахь талд). Олон тоог заах энэ дагавар XIII-XIV зууны үеийн монгол хэлний бичгийн дурсгалд, жишээлбэл: “Нууц товчоо”, мөн түүнчилэн хятад галигаар буулгасан бусад монгол бичгүүд хийгээд дөрвөлжин бичгийн дурсгалд маш элбэг гардгийг үүн дээр нэмэн хэлж болно. Энэхүү дагаврыг мөн хуучин бичгийн монгол хэлний олон олон дурсгалаас олж үзэж болох юм. Ийм жишээ баримтыг бараг тоймлож барагдамгүй тул, энэ удаад түүнийг нарийвчлан авч үзэхийн оронд саяхан нийтлэгдсэн бөгөөд энэ асуудлаархи олон тооны томоохон чухал ажиглалтуудыг агуулсан нэгэн урьдчилсан судалгааг дурдваас хангалттай буй за¹⁰.

¹⁰ E. Haenisch, *Grammatische Besonderheiten in der Sprache des Manghol un niuca tobca'an*. Helsinki, 1950, ялангуяа 4-13 дахь талыг үзмүү.

Олон тоо заах **-n** дагаврыг **᠑i** төгсгөлтэй үйлдэгчийн нэрд залгаад зогсохгүй, мөн бусад олон төрлийн нэрд залгадаг болохыг дурдалтай. Энэхүү **-n** дагаврыг үе эс бүтээх **i** бүхий хос эгшгээр төгссөн ганц тоот хэлбэрт залгасантай бид олонтаа дайралддаг. Ийнхүү **i** нь **n** болмогц чухамдаа ганц тоотоос олон тоот болж буй нь үзтэл илэрхийг харуулбал:

noqai	(нохой)	-	noqan	(олон тоот);
mawui	(муу)	-	mawun	(олон тоот);
kedüi	(хэд)	-	kedün	(олон тоот);
yabuqui	(явахуй)	-	yabuqun	(олон тоот);
qaqanu'ai	(хааны)	-	qaqanu'an	(олон тоот)

гэх мэт болой. Олон тооны хэлбэрийг илэрхийлдэг **-tan**, **-ten** дагаврыг **-tu**, **-tü** бүхий үндэстэй (үүнтэй ч мөн холбоотой болох нь мэдээж боловч) шууд хамаатай гэж үзэж болохгүй, харин **-tai**, **-tei** бүхий үндэстэй хамаатай гэж үзвэл зохихыг өдий төдий жишээ илт харуулж байна.

Зохиогч олонтаа хэрэглэдэг дагавар үгсийг 204 дэх болон түүний дараахь талуудад нэлээд үндэстэй авч үзжээ. Үүнд **metü**, **᠑inggi** гэдэг үгстэй холбогдуулан хуучин бичгийн монгол хэлнээс олдсон **sitü**-ийг бас заан хэлэлтэй. Энэ үг **metü**, **᠑inggi** гэдэгтэй утгын хувьд нийлэхээр зогсохгүй, мөн **᠑inggi** -тэй гарлын хувьд ч холбоотой учраас эш татаж байгаа юм. Эл үг “*Бодьсатвын явдалд орохуйн*” монгол орчуулгад (**uyaysan sitü**, V, 5b; **daruysan sitü**, V, 12a; **kigsen sitü**, VI, 122a гэж) хэд хэдэн удаа, мөн “*Сайн үгт эрдэнийн сангийн*” монгол эх (**qiduysan sitü** хэмээн IX, 8a; 424b), 1338 оны хятад – монгол бичээс (**keküdeglečegsen sitü** хэмээн), “*Ачлалт номын*” монгол орчуулга (**oyir-a sitü**, **gečkikü sitü** хэмээн), мөн түүнчлэн “*Нууц товчоонд*” (164 §-д **ügei sitü** хэмээн) гарч байна.

Эцэст нь тэмдэглэхэд, зохиогчийн дүгнэлтүүд нэн баялаг баримт хэрэглэгдэхүүнийг түшиглэжээ; үүгээр бидний шүүмж бичиж буй ном гарсан нь монгол судлалд томоохон үйл хэрэг боллоо гэж үзэж болно. Тус номын хоёрдугаар, төгсгөлийн ботийг бид ихэд сонирхон хүлээж байна.¹¹

¹¹ хэмээсэн үүнийг эрдэмтэн Санжийн Гармагийн номд зориулж академич Л. Лигети арав гаруй жилийн өмнө бичсэн боловч, энэ бяцхан шүүмж агуулга, үзэл санаагаар арвин баялгийн дээр монголын судлал, ялангуяа монгол хэлний түүхийн шинжлэлийн үндсэн асуудлуудыг дэвшүүлэн тодорхойлсноороо монгол хэлний судлалд онол, арга зүйн нэн чухал авлага хэрэглэгдэхүүн болсоор байна. Эл шүүмжийг хэлбичгийн ухааны дэд эрдэмтэн С. Лувсанвандангийн дурдсанаар Монголч эрдэмтдийн хоёрдугаар их хурлыг угтан эх хэлээрээ гаргахыг хичээж, ЗХУ-ын “Вопросы языкознания” сэтгүүлийн 1955 оны 5 дугаараас авч, урьд монгол хэлшинжлэлийн нэгэн дэвтрийг орчуулан Ринчин багшаар нягтлан засуулснаа дулдуйдан монгол хэлнээ буулгав. Үүнд хэлбичгийн ухааны судлалтан Ж. Төмөрцэрэн шүүмжийн зарим хэсгийг орчуулалцаж, Мажар улсын эрдэмтэн Г. Кара уг эхтэй нь тулган үзэж санал зөвлөлгөөгөө харамгүй хэлсэн хийгээд монгол хэлбичгийн багш Д. Төмөртоогоо орчуулгын найруулга засахад туслалцсаныг тэмдэглэн, тэдэнд халуун талархдаа илэрхийлж, орчуулагчийн хувиар энэ үгийг зүүлт болгов.

1. Өмнөдөр МУИС-ийн Монгол Судлалын
 Төвөөс монгол хэл, утга зохиол судлалын зарим сонгодог бүтээлийн орчуулгыг дахин нийтлэхээр
 шийдсэний дотор тус шүүмж орсон нь зүй ёсны хэрэг ээ. Ийнхүү доктор, профессор Ц.Шагдарсүрэнгийн
 дурдсанаар шүүмжийн орчуулгыг дахин нягтлав. Энэ ялдамд хэлэхэд өнгөрсөн зууны 60, 70-аад онд
 монгол судлалын сонгодог бүтээлүүдээс нэлээд орчуулсан нь чухамхүү миний дотно журмын нөхөр,
 шинжлэх ухааны нэртэй зохион байгуулагч доктор, профессор С.Лувсанвандангийн ач гавъяа байсан
 гэдгийг дурсаж, онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Эл шүүмжийг орчуулснаас хойш 35 жил өнгөрлөө. Өнөөдөр МУИС-ийн Монгол Судлалын
 Төвөөс монгол хэл, утга зохиол судлалын зарим сонгодог бүтээлийн орчуулгыг дахин нийтлэхээр
 шийдсэний дотор тус шүүмж орсон нь зүй ёсны хэрэг ээ. Ийнхүү доктор, профессор Ц.Шагдарсүрэнгийн
 дурдсанаар шүүмжийн орчуулгыг дахин нягтлав. Энэ ялдамд хэлэхэд өнгөрсөн зууны 60, 70-аад онд
 монгол судлалын сонгодог бүтээлүүдээс нэлээд орчуулсан нь чухамхүү миний дотно журмын нөхөр,
 шинжлэх ухааны нэртэй зохион байгуулагч доктор, профессор С.Лувсанвандангийн ач гавъяа байсан
 гэдгийг дурсаж, онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Академич Л. Лигетигийн шавь, залуу монголч эрдэмтэн Д. Кара (1970 оны эхээр) эл орчуулгын
 гар бичмэлийг мажар эхтэй нь тулган үзээд, орчуулагчид ирүүлсэн захидлыг энд хавсаргав. Гадаад хүн
 монгол хэл, монгол бичгээр, эрхэмсэг найруулгаар хэрхэн утга төгөлдөр бичсэн нь эх монгол хэлээ
 дээдэлдэг хэн бүхэнд, ялангуяа манай залууст сонирхолтой бөгөөд сургамжтай байх нь дамжиггүй биз ээ.

Г. Лувсанцэрэн (2006 он)